



Bank of Mongolia

# Төрөөс мөнгөний бодлогын талаарх 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

Улаанбаатар

9/25/2017

*Мөнгөний бодлогын газар*



## АГУУЛГА

### I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

- Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд
- Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд
- Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд

### III. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛУУД

ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭ

I.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД  
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН  
ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ᠲᠦᠷᠡᠭᠡᠰᠡᠮᠡᠩᠭᠡᠨᠢᠢ  
ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨᠲᠠᠯᠠᠭᠠᠷ



I.

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.
2. Монголбанкны дүрмийн сангийн хэмжээг дунд хугацаанд 100 /нэг зуун/ тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэхийг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠪᠠᠨᠭ



I.

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТЭСЭЛ

3. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.

1/ Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

2/ Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх;

3/ Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн дэд бүтцийг бэхжүүлж, түүний эрх зүйн орчинг төлөвшүүлэх;

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд үүрэг болгосугай.

ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠤᠯᠤᠰ



### 3.1 дүгээр заалт

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

#### □ Хэрэгжүүлэх байдал:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдлэг, мэдээллийг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог хангах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулж, салбарын эрсдэлийн үнэлгээ хийх суурь тавих;
- ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хянаж шийдвэрлэхэд шүүгч, прокурорын үйл ажиллагаа, ур чадварыг дээшлүүлэх, хяналт шалгалтын хүрээг нэмэгдүүлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, гэмт хэргийн замаар олсон орлого, эд хөрөнгийг царцаах, битүүмжлэх чадавхийг бий болгох, хөгжүүлэх;

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠤᠯ



### 3.2 дугаар заалт

Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх;

#### □ Үндэслэл:

- Банк, санхүүгийн салбарын өсөлт эрчимжиж, санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээ эрс нэмэгдсэн ч банкнаас бусад санхүүгийн салбарын хөгжил сул байна.
- Бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн урт хугацаатай, хүү багатай, хөрвөх чадвар бүхий хямд санхүүгийн эх үүсвэр, хэрэгслүүдээр санхүүгийн зах зээл дутагдсан хэвээр байна.

#### □ Хөтөлбөрийн зорилго

- Санхүүгийн салбарын тогтвортой өсөлтийг дэмжих, санхүүгийн дэд салбарууд эн тэнцвэртэйгээр хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх, салбарын эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэн, хямралаас урьдчилан сэргийлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

#### □ Хөтөлбөрийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.



### 3.2 дугаар заалт

Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх;

#### ❑ Хүлээгдэж буй үр дүн

- Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн зохицуулалтын орчин бүрдсэн байна.
- Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа олон улсын жишигт хүрсэн байна.
- Санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдсэн байна.
- Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь хэмжээг 2025 он гэхэд 12 хувьд хүргэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээ хоёр дахин нэмэгдэж, хөрвөх чадварын үзүүлэлт 10 хувь хүртэл өснө. Даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөн, бүтээгдэхүүний үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн байна.

#### ❑ Банкны салбар

- Банкны салбарын хяналт, зохицуулалтын тогтолцоо бэхжиж, салбарын хууль эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулан, олон улсын стандартад нийцсэн дүрэм, журам хэрэгжүүлэх бөгөөд компанийн засаглалыг сайжруулсан байна.

#### ❑ Хөрөнгийн зах зээл


- Үнэт цаас гаргагчид болон зуучлагч байгууллагуудын засаглал сайжирч, цахим технологид суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүний зах зээл төлөвшинө.





### 3.3 дугаар заалт

Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн дэд бүтцийг бэхжүүлж, түүний эрх зүйн орчинг төлөвшүүлэх;



Эрх зүйн орчин

“Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шаардлагатай зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, анхлан боловсруулна.

II.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД  
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

ᠲᠦᠷᠦᠭᠦᠰᠡ ᠮᠥᠩᠭᠡᠨᠢ  
ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠲᠠᠯᠠᠭᠠᠷ  
2018 ᠣᠨᠳᠤ  
ᠪᠠᠷᠢᠮᠲᠤᠯᠠᠬᠤ  
ᠤᠨᠳᠤᠰᠡᠨ  
ᠴᠢᠭᠯᠡᠯᠢᠶᠢᠨ  
ᠲᠥᠰᠥᠯ



## II.

# ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

- 1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:
  - 1.1. Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна.
  - 1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох зарчмыг баримтална.
  - 1.3 Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.
  - 1.4 Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгоно.


ᠮᠣᠩᠭᠦᠨ  
ᠪᠣᠳᠯᠠᠭ



# 1.1 Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна.

## □ Үндэслэл:

- Инфляцийн хэлбэлзлийг тогтворжуулах,
  - Тодорхой бус байдал, эрсдлийн үнэ нэмэгдэх,
  - Бизнессээ төлөвлөх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хүндрэлтэй байдаг.
- Хэт халалтыг дохиолох суурь инфляцид хариу үйлдэл үзүүлэх.
- Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцид хариу үйлдэл үзүүлэх нь ЭЗ-ийн шаардлагагүй агшилт бий болгоно.
- Манай орны хувьд сүүлийн 10 жилийн хугацаанд нийлүүлэлтийн шалтгаантай инфляци дунджаар тухайн хугацааны нийт инфляцийн 1/3-ийг бүрдүүлж байна.



Үндсэн чиглэлийн төсөл

Инфляци



## 1.1 Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна.

### □ Стратеги:

- 2018-2020 онд жилийн инфляцийг 8 хувийн орчимд тогтворжуулна.
- Мөнгөний бодлогыг зөвхөн зах зээлд суурилсан арга хэрэгслүүдийг ашиглан хэрэгжүүлж, хүүгийн нэгдсэн бодлого баримтлана.
- Нийлүүлэлтийн шинж чанартай инфляцид мөнгөний бодлогоор шууд хариу үйлдэл үзүүлэхгүй бөгөөд харин 2 дахь үеийн болон дам нөлөө нь өндөр үед мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан арга хэмжээ авна.
- Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтын “Төсөөлөл, бодлого, шинжилгээний систем”-ийг нутагшуулах ажлыг үргэлжлүүлнэ.

### □ Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх шийдвэрийг хараат бус, хамтын хэлбэрээр гаргаж хэрэгжүүлнэ.
- Мөнгөний бодлогын шийдвэр нь эдийн засгийн гадаад тэнцвэр, санхүүгийн салбарын тогтвортой байдал, инфляцийн дарамтгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэнэ.






## 1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох зарчмыг баримтална.

### Үндэслэл:

- Гадаад валютын ханшийн эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй уян хатан байдал нь
  - Гадаад сөрөг шокын нөлөөг шингээж, төлбөрийн тэнцэлд тохиргоо хийгдэж, гадаад валютын албан нөөцөд ирэх дарамтыг бууруулна.
  - Макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй.
  - Эдийн засгийн суурь нөхцлийг тодорхойлогч хүчин зүйлстэй нийцтэй байх.

### Стратеги:

- Ханшийн уян хатан байдлыг тодорхойлохдоо
  - Огцом хэлбэлзлийг бууруулах
  - Экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадвар
  - Санхүүгийн тогтвортой байдал (балансын долларжилт)
  - Төлбөрийн тэнцлийн ирээдүйн төлөв зэргийг харгалзан үзэх болно.



Ц.Бямбаогт, Б.Цэнгүүнжав (2016)

www.mnf.gov.mn



## 1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох зарчмыг баримтална.

### □ Хэрэгжүүлэх арга хэмжээ:


- Гадаад валютын дотоодын захын үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд банк хоорондын валют арилжааны цахим талбар, шаардлагатай тохиолдолд дуудлага худалдаа хийх хэлбэрээр валютын захад оролцоно.
- Дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд
  - Банк хоорондын валют арилжааны цахим талбар (Bmatch)-т оролцогчдын тоог нэмэгдүүлэх,
  - Мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, улмаар банк хоорондын валютын захыг идэвхжүүлж, ханш зах зээлийн зарчимд нийцтэй, бодитой тогтох нөхцөлийг бүрдүүлнэ.

МОНГОЛ  
УЛСЫН  
ХӨГЖИЛ  
БАНК



### 1.3 Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

- ❑ Мөчлөг дагасан зээлийн өсөлтөөс үүсэх системийн эрсдлийг бууруулах, санхүүгийн систем болон оролцогчдын шокод тэсвэрлэх чадамжийг тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр нэмэгдүүлэх орилготой байдаг (Б.Цэнд-Аюуш, Х. Саруул (2017)).









### 1.3 Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

- ❑ Мөнгөний бодлогоор санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудал нь тодорхой шийдэлд хүрээгүй байна (IMF, 2015).
- ❑ Хөрөнгийн дотогшлох их хэмжээтэй урсгалыг зохистой удирдах нь эдийн засгийн хэт халалт, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, урт хугацаанд эдийн засаг тогтвортой өсөх нөхцлийг бүрдүүлнэ.
  - ГШХО-ын шок банкны болон бодит секторын сувгаар дамжин эдийн засагт нөлөөлдөг. ГШХО/ДНБ 1 нэгж хувиар нэмэгдэхэд зээл 2.5 жилийн дараа 3 хувиар өндөр. (Даваажаргал, Ган-Очир (2017)).
- ❑ Мөнгөний бодлогын орон зайг нэмэгдүүлэх Зээлийн өсөлтийг тогтворжуулах хүүний өсөлт нь хөрөнгийн дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.





### 1.3 Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

#### Стратеги

- ❑ Банкуудын мөчлөг дагасан зээлийн бодлогыг хязгаарлах макро зохистой бодлого хэрэгжүүлэх замаар системийн эрсдлийг бууруулах
- ❑ Долларжилтыг бууруулан ханшийн өөрчлөлтийн санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах

#### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- ❑ Санхүүгийн системийн эрсдлийг бууруулах макро зохистой бодлогын шинжилгээний арга зүй, бүтцийг хөгжүүлэх,
  - Макро зохистой бодлого хэрэгжүүлэх шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх
  - Банкны системийн эрсдлийг тодорхойлох нэгдсэн дохиологч индикатор хөгжүүлэх ажил эхлүүлэх
  - Улс орнуудын сайн туршлагыг судалж, шаардлагатай тохиолдолд тохирох арга хэмжээг авах



**1.4** Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ.

Бүдүүвч 1. Мөнгөний бодлогын үр нөлөө ба хүлээлтийг удирдах нь (BIS No35, 2008)



Хүлээлтийн өөрчлөлт ялангуяа ханш болон инфляцийн хүлээлтийн өөрчлөлт нь мөнгөний бодлогод итгэх итгэлээс хамааран мөнгөний бодлогын шилжих механизмын үр нөлөөг улам бүр нэмэгдүүлдэг (Пиер-Ричард, 2008).

Үндсэн чиглэлийн төсөл

ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠪᠠᠨᠠᠭ



## 1.4

Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ.

### □ Үндэслэл:

- Мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, тогтмол давтамжтайгаар, хүртээмжтэй тайлбарлан таниулах нь орчин үед мөнгөний бодлогын салшгүй нэг хэсэг юм.
- Төв банк олон нийттэй нээлттэй, ил тод харилцах замаар инфляцийн хүлээлтийг удирдах чадавх улмаар мөнгөний бодлогын үр нөлөө нэмэгдэх боломж бүрдэнэ.
  - Санхүүгийн зах зээлд хүлээгдээгүй шинэ мэдээллийг олон нийтэд хүргэх
  - Тодорхой бус байдлыг бууруулах замаар иргэд, ААН байгууллагын хүлээлтийг удирдах
- Мөнгөний бодлогын шийдвэр аль болох зах зээлд таамаглахуйц байхад чиглэгдэнэ.
- Зах зээлд оролцогчдын эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг, санхүүгийн зах зээлд оролцогчдын нарийн мэдлэг, эрсдлийн удирдлага, бизнес төлөвлөлт, алсын хараа зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.



## 1.4 Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ.

### □ Стратеги:

- Үнийн тогтвортой байдлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, ач холбогдол, макро тогтвортой байдлын зайлшгүй нөхцөл болохыг өргөн хүрээнд тодорхой, тайлбарлан таниулна.
- Бодлогын шийдвэр, хэрэгжилтийг тогтсон давтамжтайгаар, тодорхой хуваарь гарган, цогц байдлаар нийгмийн ялгаатай бүлгүүдэд тохирсон сувгаар тайлбарлаж түгээнэ.

### □ Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- МБЗ-ийн хурал зохион байгуулах, МБ-ын шийдвэр гаргах болон инфляцийн тайлан гаргах товыг олон нийтэд оны эхэнд урьдчилан зарлаж, уг товыг оны туршид баримтлан ажиллана.
- МБ-ын шийдвэр гарсан даруйд хэвлэлийн хурлыг зарлаж, бодлогын арга хэмжээний үндэслэлийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах.
- МБ-ын шийдвэрүүд, тэдгээрийг гаргаж буй үндэслэл, МБ-ын үндсэн зорилттой нийцэж буй байдал, инфляцийн тайлан, төв банкнаас авч үзэж буй макро эдийн засгийн ирээдүйн төлөвийг иргэд, хувийн аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд, санхүүгийн зах зээлд оролцогчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд зэрэг нийгмийн төрөл бүрийн зорилтот бүлгүүдэд тусгайлан чиглэгдсэн байдлаар тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж хэвшүүлнэ.

ᠮᠣᠩᠭᠡᠯᠢᠨ ᠪᠠᠨᠭ



## II.

# ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

- 2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:
  - 2.1 Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх, банк санхүүгийн байгууллагын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор шаардлагатай тохиолдолд банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, санхүүгийн чадамжийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
  - 2.2 Банкны салбарт итгэх итгэлийг дээшлүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгоно.

ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨ  
ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨ



## 2.1

Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх, банк санхүүгийн байгууллагын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор шаардлагатай тохиолдолд банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, санхүүгийн чадамжийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### □ Үндэслэл:

- Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан банкуудын активын чанар муудаж, банкны салбарын төлбөрийн чадварт дарамт үзүүлж, зээл олголт тасалдах эрсдэл үүсч болзошгүй тул санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны салбарыг эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон.

### □ Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарын активт чанарын иж бүрэн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлж, үнэлгээний үр дүнг үндэслэн системд нөлөө бүхий банкуудыг дахин хөрөнгөжүүлэх хөрөнгийн хэмжээг тодорхойлж, төлбөрийн чадавхийг зохих түвшинд хүргэх арга хэмжээг Монголбанк, Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуурыг хангаагүй банкуудад дутагдлыг арилгах хугацааг ОУВС-ийн хөтөлбөрийн нөхцөлийн дагуу олгоно.
- Дахин хөрөнгөжүүлсэн банкныг мэргэжлийн түвшинд удирдах, үйл ажиллагааг сайжруулах, тухайн банкны зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх банкны удирдлагын багийг бүрдүүлнэ.
- Үйл ажиллагаа нь хэвийн болсон банкны төрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг зах зээлийн зарчмын дагуу хувийн хэвшилд шилжүүлнэ.





2.1

Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх, банк санхүүгийн байгууллагын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор шаардлагатай тохиолдолд банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, санхүүгийн чадамжийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ (AQR) хийнэ

ОУВС-н хөтөлбөрийн хүрээнд банкуудын Активын чанарын үнэлгээ хийж банкуудын одоогийн нөхцөл байдлыг үнэлж бүтцийн өөрчлөлтийн зардлыг тооцно.

### ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Активын үнэлгээгээр өөрийн хөрөнгө дутсан банк нь 6 сарын хугацаанд **өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх төлөвлөгөөг 3 жилийн бизнес төлөвлөгөөний хамт гаргана.**

### ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ

Системийн ач холбогдолтой банкиыг ЗГ, МБ хамтран дахин хөрөнгөжүүлнэ

Мэргэжлийн удирдлагын баг ажиллана

Зохион байгуулалт, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулан зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх

### ХЭВИЙН БОЛСОН БАНКИЙГ ХУВИЙН ХЭВШИЛД ШИЛЖҮҮЛНЭ

Дахин хөрөнгөжүүлэлт хийгдсэн банк хэвийн болсны дараа банкиыг хувийн хэвшилд шилжүүлж Төрөөс оруулсан хөрөнгийг буцаан авна

ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨ  
ᠪᠠᠨᠠᠭᠢᠨ





## 2.2

Банкны салбарт итгэх итгэлийг дээшлүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгоно.

### □ **Үндэслэл:**

- Банкинд хяналт шалгалтыг хийх явцад илрүүлсэн зөрчилд Монголбанк албадлагын арга хэмжээг ногдуулдаг боловч нэгэнт үүсчихсэн алдагдлыг барагдуулах, хязгаарлахад хүндрэлтэй, цаашдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.
- Олон улсын туршлагаар хяналт шалгалт нь зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч, эрсдэлд суурилсан, ирээдүйд чиглэсэн хэлбэрээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зохисгүй удирдлагаас үүсэх алдагдал, хохирлыг хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ирээдүйд чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх.

### □ **Стратеги:**

- “Банкны тухай хууль”-д дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд: системд өндөр эрсдэл хуримтлуулж болзошгүй, банкны салбарын тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй зарим үйл ажиллагааг урьдчилан хязгаарлах, таслан зогсоох, зарим тохиолдолд татвар төлөгчдийн хөрөнгөөр банкны системд дэмжлэг үзүүлэх оновчгүй үйл ажиллагааг хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ирээдүйд чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх
- Банкуудын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагад тавих шаардлагыг өндөржүүлж банкны системийн засаглалыг бүхэлд нь сайжруулах арга хэмжээг авна.

### □ **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ирээдүйд чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн заалтуудыг “Банкны тухай хууль”-ийн төсөлд тусгаж УИХ-д өргөх барих.
- “Банкны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсны дараагаа хяналт шалгалттай холбоотой холбогдох журам зааварт өөрчлөлт оруулан батлах.



## II.

# ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

- 3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:
  - 3.1. Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн, шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан, нэмэлт, өөрчлөлт орсон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулна.
  - 3.2. Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, төлбөрийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалтыг бий болгоно.
  - 3.3 Олон улсын, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
  - 3.4. Мөнгө, санхүү, гадаад секторын статистик мэдээллийг олон улсын мэдээлэл тархаах тусгай стандартын дагуу нийтэд мэдээлэлж эхэлнэ.

ᠮᠣᠩᠭᠡ



### 3.1

Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн, шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан, нэмэлт, өөрчлөлт орсон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулна.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-10 болон 2017 оны А-97 дугаар тушаалаар “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн хүрээнд:
- Монголбанкны боловсруулсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2017 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэж батлуулсан болно.
- Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль,
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль,
- Эрдэнэсийн сангийн тухай хууль,
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль,
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Валютын зохицуулалтын тухай хууль,
- Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,
- Активын удирдлагын тухай хуулийн төслийг шинээр боловсруулах,
- нийт 9 хуулийн төслийг хууль санаачлагчид уламжилж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.



## 3.2 Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, төлбөрийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалтыг бий болгоно.

### □ Үндэслэл:

- Төлбөр тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай үед өөрчлөлт оруулах замаар төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангуулан, төлбөрийн системд хяналт тавих.
- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаар цахим мөнгө зэрэг төлбөрийн хэрэгслүүдтэй холбоотой харилцааг зохицуулах нэгдсэн зохицуулалтыг бий болгоно.
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгосноор техник технологийн хөгжлийг даган гарч ирж буй FINTECH буюу технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах боломж бий болж байна.

### □ Стратеги

- Төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх
- Үндэсний төлбөрийн системд тавих хяналтыг илүү үр дүнтэй болгох, төлбөр тооцооны “Банксүлжээ” системийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх
- Төлбөр тооцооны болон клирингийн системүүдийн харилцан зохицолдоог хангах замаар бэлэн бус төлбөрийн хэрэгслийг дэмжих



## 3.2 Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, төлбөрийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалтыг бий болгоно.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоог дэмжих, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан **төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.**
- Төлбөрийн системийн хамрах хүрээ өргөжиж, төлбөр хийх, мөнгө шилжүүлэх зэрэг нь хэрэглэгчид хялбар болж байгаа хэдий ч хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа тул уламжлалт төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ төдийгүй төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг шинээр гарч ирж буй төлбөрийн хэрэгсэл, мобайл, интернэт банкны үйлчилгээ зэрэг **төлбөрийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, холбогдох журам, заавар, баримт бичгийг боловсруулна.**
- Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээ, техник тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэн сайжруулах, нөөц төв болон бусад дэд бүтцийг олон улсын стандартын түвшинд хүргэж, нягтлан бодох бүртгэлийн үндсэн системийг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.



### 3.3 “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- **Үндэслэл:**
- Судалгаагаар иргэд олон нийтийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг олон улсын түвшинтэй харьцуулахад хангалтгүй, хуримтлал болон хөрөнгө оруулалтын хамгийн үр өгөөжтөй шийдвэр гаргах, хууль ёсны эрхээ хамгаалуулахад шаардлагатай санхүүгийн үндсэн ойлголтын талаар хязгаарлагдмал мэдлэгтэй байгаа нь харагдсан байна.
- **“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан тушаалаар батласан байна.**

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭ



### 3.3 “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.



#### **Цаашид хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:**

- Иргэдийн хувийн санхүүгийн талаархи мэдлэг буюу хяналттай төсөвлөлт хийх, ирээдүйн хэрэгцээндээ зориулж нөөц, хуримтлал үүсгэх, ирээдүйн тухай тунгаах чадамж нь дээшилнэ.
- Хадгаламжтай иргэдийн тоо өснө.
- Хөрөнгийн зах зээлд иргэдээс оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- Даатгалтай иргэдийн тоо өснө.
- Иргэдийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өрийн хэмжээ буурна.
- Нэг хүний хэрэглэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ өснө.
- Санхүүгийн бүтээгдэхүүнийг мэдээлэл, мэдлэг дээр үндэслэн зөвөөр сонгох байдал нэмэгдэнэ.
- Санхүүгийн залиланд өртсөн иргэдийн тоо буурна.





### 3.4 Мөнгө, санхүү, гадаад секторын статистик мэдээллийг олон улсын мэдээлэл түгээх тусгай стандартын дагуу нийтэд мэдээлэлж эхэлнэ.

#### □ **Үндэслэл:**

- ОУВС статистик мэдээлэл тархаах стандартыг сайжруулж “Мэдээлэл түгээх тусгай стандарт (МТТС)”-ыг 1996 онд боловсруулсан. МТТС нь стандарчилагдсан тодорхойлолт, давтамж, хэлбэрийн дагуу статистик мэдээллүүдийг олон нийтэд зайлшгүй зарладаг стандарт юм.
- МТТС-д нэгдэн орсноор статистикийн чанар сайжирна, тухайн улсын статистик мэдээлэлд итгэх итгэл нэмэгдэнэ, ил тод байдал сайжирч, судалгаа шинжилгээний ажилд эерэг нөлөө үзүүлнэ.

#### □ **Стратеги:**

- Тоон мэдээллийг нэгдсэн аргачлалаар боловсруулж, улирал болгон цахим хуудаст байршуулна.
- Статистик тоон мэдээллийн тархаалтын хугацаа, давтамж, хэлбэр нэг түвшинд ижил байлгахыг чухалчилж тоон мэдээллийн чанарыг өндөр түвшинд байлгана.

#### □ **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- МТТС-д нэгдсэн улс орнуудын туршлагыг судлаж, мөнгө, санхүүгийн болон гадаад секторын статистикийг МТТС-ын дагуу бэлтгэх төлөвлөгөөг боловсруулах
- Санхүүгийн тогтвортой байдлын индикаторуудыг холбогдох стандартын дагуу тооцох
- Гадаад валютын улсын нөөцийн статистик мэдээллийг олон улсын стандартын дагуу боловсруулж, олон нийтэд мэдээлэх.





# Анхаарал хандуулсанд баярлалаа

Қазақстан Республикасының  
Білім және Ғылым Министрлігі